



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/588

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайн хүрээний Бандида ламтаны 6 дугаар дүрийн хувилгаан Данзанжамъянлодан Бүгд Найрамдах Энэтхэг улсаас төрөлх нутаг Өвөрхангай аймагт хүрэлцэн ирж байгаатай холбогдуулан хүлээн авах хүндэтгэлийн зардалд 4.243.250 (дөрвөн сая хоёр зуун дөчин гурван мянга хоёр зуун тавь) төгрөг, Францын элчин сайд, Францын Аллиер мужийн төлөөлөгчдийг хүлээн авах зардалд 2.752.088 (хоёр сая долоон зуун тавин хоёр мянга наян найм) төгрөг, нийт 6.995.338 (зургаан сая есөн зуун ерэн таван мянга гурван зуун гучин найм) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101079